Тус нутаг нь Монгол орны хөрсний мужлалаар гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн хөрсний бүсэд хамаарна. Энэ бүсийн тал хээр нутгаар цайвар хүрэн, бор хөрс, голын хөндийн хэсгээр аллювийн нугын хөрс, элсэрхэг цайвар хүрэн, бор хөрс голлон тархсан байдаг [БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990].

Төслийн талбайд делювийн гарал үүсэлтэй хурдас дээр бий болсон, хөнгөн шавранцар болон элсэнцэр цөлөрхөг хээрийн бор хөрс тархсан байна. Судалгааны явцад 2022 онд 2 цэгт хөрсний дээж авч, морфологи бичиглэл хийсэн бөгөөд 5 дээжинд агрохимийн, 1 дээжинд хүнд металлын агууламжийг тодорхойлов.

Зураг 16. Хөрсний зүсэлт №1, орчны зураг




Цөлөрхөг хээрийн хөнгөн шавранцар бор хөрс.

А (0-20 см): Боровтор өнгөтэй, хатуурч нягтарсан нунтаг тоосонцор бүтэцтэй, ургамлын үндэс их, үйрмэг чулуугүй, нягтавттар нийцтэй, хөнгөн шавранцар, 20 см-ээс хатуурч хөрс хүндэрч байна.

Зураг 17. Хөрсний зүсэлт №2, орчны зураг



Зураг 18. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг



Хүснэгт 20. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	350.4	61.8
	Цөлөрхөг хээрийн нугат бор хөрс	64.0	11.2
	Цөлөрхөг хээрийн бор хөрс	152.7	27.0
	Нийт	567.1	100.00

Хөрсний дээжийн лабораторийн задлан шинжилгээний дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 21. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд

Гүн см	pH	Давс %	EC ₂₅ Ds/m	Ялзмаг %	CaCO ₃ %	NO ₃ мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент мг/100	
							Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж-1										
0-20	8.16	0.029	0.079	1.93	0.0	0.13	12	8	1.0	20
Дээж-2										
0-20	8.13	0.351	0.964	1.41	1.12	0.37	14	20	1.6	18
20-45	8.10	0.603	1.657	1.27	1.28	0.49	11	23	2.4	6
45-75	8.01	1.411	3.880	0.79	1.44	0.67	14	47	3.1	4
Дээж 3										
0-20	7.84	0.019	0.053	1.58	0.0	0.16	15	5	1.2	18

Хүснэгт 22. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ /мм, хувиар/						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1	0-20	29.6	38.5	10.3	8.0	10.2	3.5	21.7
Дээж 2	0-20	29.9	40.3	15.0	6.1	4.3	4.5	14.9
	20-45	33.2	40.1	11.2	6.0	4.5	5.0	15.5
	45-75	25.3	43.0	12.2	7.6	4.5	7.3	19.4
Дээж 3	0-20	27.0	44.5	4.5	12.2	7.2	4.5	24.0

Хүснэгт 23. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
1	0-20	71.5	50.4	0.0	84.8	43.5	40.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1,5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/ атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад дээж № 3 дээжинд хром 71.5 мг/кг, хар тугалга 50.4 мг/кг, цайр 84.8 мг/кг, зэс 43.5 мг/кг, никель 40.5 мг/кг агууламжтай, харин кадми илэрсэнгүй. Дээрх хүнд металлуудын агууламж MNS 5850:2019 стандартад тусгасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага юм.

2.7. УРГАМЛАН НӨМРӨГ

Судалгааны явцад 3 цэг дээр ургамалжилт, төлөв байдлын бичиглэл хийж, ургамалжилтын төрхөөр цөлөрхөг хээрийн ургамалжилтын дараах 3 үндсэн бүлгэмдэлтэй байгааг тогтоов. Үүнд:

- Их талхлагдсан Монгол өвс-заримдаг сөөгөнцөрт
- Сийрэг дэрст
- Их талхлагдсан Монгол өвс-заримдаг сөөгөнцөр-дэрст

Хүснэгт 24. Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал

Ургамлын бүлгэмдэл	Талбай, га	Дүнд эзлэх хувь
Их талхлагдсан Монгол өвс-заримдаг сөөгөнцөрт	350.4	61.8
Сийрэг дэрст	152.7	27.0
Их талхлагдсан Монгол өвс-заримдаг сөөгөнцөр-дэрст	64.0	11.2
Дүн	567.1	100.00

Судалгаанд хамрагдсан нийт газрын өвс ургамлан нөмрөг нэлээд талхлагдсан, ургамлан бүрхэвчийн унаган төрх нь алдагдсан байна.


Зураг 19. Ургамлан бүрхэвчийн эзлэх талбайн хэмжээ, диаграмм



Зураг 20. Өмнө нь олборлолт явуулж байсан талбай



Зураг 21. Төсөл хэрэгжих талбайн ургамлын бүлгэмдэлийн тархалт



2.8. АМЬТНЫ АЙМАГ


2.8.1. Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг

Тус нутаг нь хөхтөн амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954)–аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна.

2.8.2. Төслийн талбайн амьтны аймаг

Алтны шороон ордыг ил аргаар ашиглах талбай нь уулын хээр, тал хээр зонхилсон нутаг байв. Тус төслийн талбайн эхэнх хувийг тал хээр, нам уулын хөндийгөөс бүрдэх ба нам уул, толгод зэрэг нь цөөн хувийг эзэлдэг. Уурхайн талбай орчимд амьдардаг шавж, мөлхөгчид, хоёр нутагтан, хөхтөн болон шувуудын зүйлийн бүрдлийг бүрэн бүртгэх тогтоох боломжгүй байв. Учир нь нүүдлэн ирж зусдаг амьтад нүүдлэн ирээгүй байснаас гадна тус сард шавжийн судалгаа хийх тохиромжтой улирал биш байв. Учир нь энэ улиралд шавжийн идэвхижил байхгүй учир. Хэдий улирлын байдал тийм тохиромжтой байгаагүй ч уурхайн талбайд суурин амьдардаг цөөн тооны амьтдыг бүртгэв. Мөн энэ нутгийн уугуул оршин суудаг иргэд, энэ нутагт урьд нь амьтны аймгийн судалгаа хийж байсан түүхэн мэдээллийг тусган энэхүү тайланд баяжуулсан болно.

Уурхайн талбайн амьтны аймгийн судалгаагаар 1 зүйлийн шавж, 6 зүйлийн хоёр нутагтан мөлхөгчид, 21 зүйлийн шувуу, 6 зүйлийн хөхтөн, нийт 3 зүйлийн сээр нуруутан амьтдыг бүртгэн тэмдэглэв.




Зураг 22. Нийт бүртгэлд орсон амьтны аймаг

2.9. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Төсөл хэрэгжих талбай нь Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Төслийн талбайн захын цэгээс зүүн хойд зүгт Хангайн нуруу БЦГ 53.3 км, хойд зүгт Хүрэн бэлчир ДГ 93.4 км, баруун хойд зүгт Хүрээ мандал БНГ 141.3 км зайд тус тус байрлаж байна.

Зураг 23. Төсөл хэрэгжих талбайн орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутаг




Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Тус нутаг нь сумын чанартай тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй бөгөөд Баянхонгор нэртэй аймгийн ОНТХГ-тай давхцалтай байна.

Хүснэгт 25. Сумын чанартай орон нутгийн тусгай хэрэгцээт газар

№	Сумын ОНТХГ-ын нэр	Аймаг, сумын нэр	Зүг	Зай, км /төслийн талбайгаас/
1	Жаргалантын гол	Баянхонгор аймаг Баян-Овоо сум	Зүүн хойд	30.1 км
2	Хойд үүдийн нуур	Баянхонгор аймаг Баян-Овоо сум	Баруун хойд	18.2 км
3	Олон нуурын хөндий	Баянхонгор аймаг Баян-Овоо сум	Баруун хойд	32.5 км
4	Урт дэл хайрхан	Баянхонгор аймаг Баян-Овоо сум	Баруун хойд	50 км
5	Алаг толгой шанаган	Баянхонгор аймаг Баян-Овоо сум	Баруун	36.5 км

Зураг 24. Төсөл хэрэгжих талбай орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг



БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

“Дөвөнтийн ам”-ны доод хэсгийн нэртэй орд нь 1:100000 масштабтай байрзүйн L-47-69 хавтгайн баруун хэсэгт MV-022142 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 567.19 га талбайг хамран орших ба ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт харъяалагдана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун урагш 700 орчим км, Баянхонгор аймгийн төвөөс баруун тийш 60 км, Баян-Овоо сумын төвөөс баруун урагш 10 км, Гучингийн бригадын төвөөс 15 км зайд тус тус оршино.

Төслийн байршилтай холбоотой асуудлыг тодруулах, тэдгээрийн төсөлтэй холбоотой байх шалтгааныг авч үзсэн бөгөөд тэдгээрээс төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

Хүснэгт 26. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл


Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Байхгүй.
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх	Цаг уурын өөрчлөлтөд эмзэг, тухайлбал : - Орон нутагт хүчтэй салхи шуурга болох магадлалтай, шуурга болсон тохиодолд нөлөөллийн эрчим дунд зэрэг - Үер, усны болзошгүй эрсдэлтэй - Газрын гадаргыг эвдэж, газрын хэвлийд хоосон орон зай үүсгэнэ. - Овоолго үүсгэсэнээр газрын гадаргад шинээр өндөршилт бий болж чулуулагт статик ачаалал үзүүлнэ.
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Давхцалгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх хуримтлагдах нөлөөлөлд агаарын бохирдолоор дамжин явагдах газрын хэвлийн өнгөн давхаргын бохирдол, хөрсний бохирдол болон ургамлан нөмрөгийн талхагдал тус тус хамаарна.

“Дөвөнтийн ам”-ны доод хэсгийн Хар толгой нэртэй MV-022142 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь нийт 567.19 га талбайг хамран байрлаж байна.

Хүснэгт 27. Төсөл хэрэгжих талбайн ашиглалтын төлөв байдал /2023 оны байдлаар/

№	Үзүүлэлт	Төлөв байдал	Талбай, га
1	Талбай-1	Их талхлагдсан сөөгөрхөг	350.4
2	Талбай-2	Элсэрхэг	64.0
3	Талбай-3	Чулуурхаг, их талхлагдсан	151.8
4	Кемп	Чулуурхаг, их талхлагдсан	0.9
	Дүн		567.1

Зураг 25. Төсөл хэрэгжих талбайн газрын төлөв байдал



3.2. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл :

- Ил уурхай, овоолго, зам болон бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх
- Ил уурхайн ухаашаас газрын хэвлийг эвдэх
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх
- Ил уурхай, баяжуулах хэсэг, уурхайн тосгоны объектууд, бусад агуулах, зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах зэрэг сөрөг нөлөөтэй.

Хүснэгт 28. Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Алт олборлох үйл ажиллагааны нөлөөгөөр ил уурхай 11.52 га, овоолго, суурин, зам зэрэг бусад 1.72 га нийтдээ 13.24 га талбай эвдрэлд өртөнө.				X	
2	Ил уурхайн ашиглалтын төлөвлөлтөөр 2.7-3.1 м гүнтэй ухаш үүсч газрын хэвлийд сөргөөр нөлөөнө.			X		
3	Хөрсний овоолго		X			
4	Уурхайн барилга байгууламж барих талбай			X		
5	Тээвэрлэлт хийх зам		X			
	Нийт		2	2	1	
	Эзлэх хувь, %		40%	40%	20%	

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
Дүгнэлт - Нийт нөлөөллийн 20% нь их, 40% нь дунд, 40% нь багагэсэн ангилалд багтаж байгаагаас алт олборлох төслөөс тухайн нутгийн газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөллийн зэргийг Дунд зэрэг гэж дүгнэж байна.						

3.3. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн зүгээс агаар орчинд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ.

Хүснэгт 29. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Ил уурхайн олборлолтоос үүсэх тоос			х		
2	Тээвэрлэлтээс үүсэх тоосжилт. Автотээврийн замуудаас үүсэх тоосжилт цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 50-250 м зайд сарнина.			х		
3	Бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас асгарч болох тоос шороо		х			
4	Хөрсний овоолго үүсгэснээс гарах тоос		х			
5	Машин механизмын дуу чимээ		х			
6	Уурхайн механизмуудын яндангаас ялгарах хорт хий		х			
	Нийт		4	2		
	Эзлэх хувь, %		66.7%	33.3%		
Дүгнэлт- Нийт нөлөөллийн 66,7% нь “дунд”, 33,3% нь “бага” гэсэн ангилалд багтаж байгаагаас алт олборлох төслөөс тухайн нутгийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн зэргийг ДУНД гэж дүгнэж байна.						

3.4. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

- ТЭЗҮ –д дурдсанаар төсөл хэрэгжих хугацаанд 3.24 мян.м³ шимт хөрс хуулж, нийт 13.24 га талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулахаар байна.
- Машин техникийн нөлөөгөөр зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсэх
- Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон усаар угаагдаж элэгдэх
- Хөрс эвдэрч физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах
- Цөлжилт нэмэгдэх
- Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох
- Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах

Хүснэгт 30. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Олборлолтын үйл ажиллагааны нөлөөнөөс байгалийн үзэмж алдагдаж хөрс хүчтэй эвдрэлд орох			x		
2	Газрын гадаргуу, хөрсөн бүрхэвчийн тогтоц алдагдаж хөрсний үржил шимт үнэт нөөц багасах			x		
3	13.24 га талбайн хөрс нөлөөлөлд өртөж, 3.24 мян.м ³ шимт хөрс хуулагдана.				x	
4	Авто машины зам харгүй гарч хөрс эвдрэх, бүтэц нь алдагдаж тоосжилт ихсэнэ, хөрс талхлагдаж, доройтолд орох			x		
5	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал		x			
	Эзлэх хувь, %		20 %	60 %	20 %	

Дүгнэлт - Нийт нөлөөллийн 20 хувь нь Их, 60 хувь нь Дунд, 20 хувь нь бага гэсэн ангилалд багтаж байгаа тул алтны уурхайн төслөөс тухайн нутгийн хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөллийн зэргийг Дунд гэж дүгнэж байна.

3.5. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

- Уурхайн үйл ажиллагааны улмаас байгалийн унаган төрх алдагдан урсац зохицуулах чадавхи буурах, усны ууршилт, нэвчилтээр усны алдагдал бий болох байдлууд үүснэ.
- Хөрсөнд хаясан, асгарсан шингэн /шатах тослох материал/ болон хатуу хаягдлууд хур тунадасны нөлөөгөөр газрын үе давхаргуудад нэвчин бохирдлыг үүсгэнэ
- Цас борооны усаар хог хаягдал зөөгдөн тархаж хөрс орчныг бохирдуулах
- Газрын доорх усны нөөц багасах, горим нь өөрчлөгдөх, зэрэг нөлөөлөл үүсч болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Уурхайн технологит ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Гадаргын усанд шууд нөлөөлөл үзүүлэхгүй.

Хүснэгт 31. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Төслийн явцад гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл	x				
2	Төслийн явцад гүний усанд үзүүлэх нөлөөлөл			x		
3	Хог хаягдлын нөлөөгөөр усны чанарт үзүүлэх нөлөөлөл		x			
	Нийт	1	1	1		
	Эзлэх хувь, %	33.3	33.3 %	33.3 %		

Дүгнэлт- Нийт нөлөөллийн 33.3% нь Дунд, 33.3% нь бага, 33.3% нь нөлөөгүй гэсэн ангилалд багтаж алтны уурхайн төслөөс тухайн нутгийн усны нөөц, чанарт нөлөөлөх нөлөөллийн зэргийг ДУНД зэрэг гэж дүгнэж байна.

3.6. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хөрс хуулалтын үед үүсэх тоосжилт нь ургамлын физиологийн үйл ажиллагаанд нөлөөлөх.
- Дам байдлаар олборлолт явуулсан талбайн ургамлын аймгийг ядууруулах, улмаар энэ бүхнээс зарим ашигт ургамлын тархац, нөөц багасах, бэлчээрийн ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, цөлжих явцад түлхэц үзүүлэх зэрэг сөрөг үр дагавартай.
- Тоосжилтын нөлөөгөөр тухайн орчны ургамлын зүйлүүдийн навчны амсрын эс бөглөрч, физиологийн хэвийн үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрснээр аажмаар үхэхэд хүргэнэ.

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Уурхайн барилга байгууламж барих, уурхайн олборлолт			х		
2	Уурхайн талбай доторх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн			х		
3	Хатуу шингэн хог хаягдал		х			
	Нийт		1	2		
	Эзлэх хувь, %		33.3 %	66.7 %		

Дүгнэлт - Нийт нөлөөллийн 66.7 % нь дунд, 33.3 % нь бага гэсэн ангилалд багтаж байгаа тул алтны уурхайн төслөөс тухайн нутгийн ургаман нөмрөгт нөлөөлөх нөлөөллийн зэргийг ДУНД гэж дүгнэж байна.

БҮЛЭГ-4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	-	-	тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 5973:2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ
	Овоолго болон тээвэрлэлтийн үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгаа хийнэ.	Үйлдвэрийн байранд	-	Усны төлбөрт багтсан	2024 онд	
	Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Үйл ажиллагааны турш	-	-	2024 онд	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, засвар үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш	-	-	2024 онд	
Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ.	Үйл ажиллагааны турш	750.0	750.0	2024 онд	
	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээг хийх)	Уурхайн дотоот замд	-	350.0	2024.08 сард	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Ажиллах хугацаанд бүх хүнд	ҮАЗ-д	ҮАЗ-д	Сар бүр	
Нийт				1 100.0		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ						
Ус ашиглах	Гүний худагт хамгаалалтын бүс тогтоож ажиллах	Төслийн хүрээнд	500.0	500.0	2024 оны 8 сард	MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээг байгуулж ажиллах, төлбөрийг цаг тухай бүр төлөх	Уурхайн ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	2024 онд	Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төлөвлөлт боловсруулах	Үйл ажиллагааны турш	-	-	2024 онд	Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982
	Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Талбайн сайруудад	-	-	2024 оны 8 сард	БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
Нийт				500.0		
Хөрс, ургамлан бүрхэвч						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м -ээс өндөргүй овоолон хадгалах	Үйл ажилллагааны турш		ҮА зардалд	Шимт хөрс хуулах үед	MNS 3307:1991, MNS 3308:1991
	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох	Үйл ажилллагааны турш	-	1242.0	2024 онд	Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	-	-	Тогтмол	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн талбайд	-	-	2024 онд	
Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав	2024 онд	
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд	-		Сард 2 удаа	
Нийт зардал				1 242.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал				2 842.0		

4.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Хүснэгт 33. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Талбай		Эзлэхүүн		Зардлын хэмжээ		Солбицол		
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	№	Өргөрөг	Уртраг
1	Техникийн нөхөн сэргээлт-Гадаад овоолго/	га	0.41	м ³	25000	Сая.төг	1.21	1	46 16 34.55	100 18 38.16
									46 16 35.07	100 18 40.54
									46 16 32.94	100 18 41.06
									46 16 33.09	100 18 38.98
2	Техникийн нөхөн сэргээлт-хөрс/ /шимт	га	5.53	м ³	25991	Сая.төг	2.55	2	46 16 35.03	100 18 40.98
									46 16 36.47	100 18 41.87
									46 16 36.60	100 18 43.48
									46 16 36.21	100 18 45.50
									46 16 32.59	100 18 51.01
									46 16 29.42	100 19 00.11
46 16 24.69	100 19 06.51									

№	Үзүүлэлт	Талбай		Эзлэхүүн		Зардлын хэмжээ		Солбицол		
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	№	Өргөрөг	Уртраг
									46 16 23.37	100 19 04.87
									46 16 30.78	100 18 48.41
									46 16 32.62	100 18 43.24
3	Биологийн нөхөн сэргээлт-Шимт хөрс	га	5.53	м ³	5530	Сая.төг	2.12	3	46 16 35.03	100 18 40.98
									46 16 36.47	100 18 41.87
									46 16 36.60	100 18 43.48
									46 16 36.21	100 18 45.50
									46 16 32.59	100 18 51.01
									46 16 29.42	100 19 00.11
									46 16 24.69	100 19 06.51
									46 16 23.37	100 19 04.87
									46 16 30.78	100 18 48.41
									46 16 32.62	100 18 43.24
	Нийт						5.88			

4.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 34. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа
1	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Нөхөн сэргээлт 2024 хөтөлбөрийн хүрээнд “Индэрт” нэртэй газарт гар аргаар алт олборлогчдын нөлөөлөлд өртсөн 2 га эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх		-	13 700.0	2024 онд
		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хамрагдаж нэгдсэн зохион байгуулалтаар мод тарьж, ургуулах, арчилж хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэх	200 ш мод	-		2024 онд
					13 700.0	

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын (саван, шампунь, угаалгын нунтаг) бодисоос өөр химийн болон цацраг идэвхт бодис хэрэглэгдэхгүй. Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 35. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	-	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль орчны мэргэжилтэн хариуцна/
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	300.0	2024 оны 8 сард
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Нийт 800.0 x 1 жил = 800.0	2024 он

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	300.0	8 сард
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Дотоод зардалд тусгагдсан	8 сард
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	-	8 сард
НИЙТ ЗАРДАЛ			1 400.0

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 36. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Төслийн талбайд	-	400.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт хогийг ангилан ялгаж хаях хогийн савуудыг байрлуулах	Төслийн хүрээнд	-	-	3 сард нэг удаа	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр	-	Сар бүр	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр	-		
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Төслийн ажилчид	-	-	Сар бүр	

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924 : 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашиглах	Ажилчдын сууринд	-	-	2024 оны 08 сард	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардалд тусгах	2024 оны 08 сараас	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 5885:2016
НИЙТ ДҮН				400.0		

4.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 37. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	-	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Төв замаас төслийн талбай хүртэлх замыг хайрган хучилттай болгох, засч сайжруулах	-	СНБАХТ-нд тусгав.	Төслийн хугацаанд	
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	28 хүн	Төсөв баталж хэрэгжүүлэх	2024 онд	
Төслийн талбайн автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох	Тээврийн хэрэгслийн зогсоол	Төсөв баталж хэрэгжүүлэх	2024 онд	
Галын аюулгүй байдлын дүгнэлтийг Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Төслийн хүрээнд	-	2024 онд	
Нийт, мян.төг			-	

4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 38. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн тайлан	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	Компаний байранд
Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо	Хэвлэмэл болон цахим тайлан		Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	Хариуцсан мэргэжилтэн	-	Сумын удирдлагын ордон
Багийн ИНХ	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Жил бүрийн 10 сарын 25-ны дотор		-	Багийн ИНХ-ын байранд
Нийт					-	

4.10. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 39. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын чанар							
Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM2.5, PM10) шинжилгээ хийлгэж байх	Агаар-1 46° 16' 35.81" 100° 19' 03.06"	8 сард	1	60.0	120.0	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 4585:2016 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм, түвшиний хэмжээ
Дуу шуугиан, чичиргээний хэмжилт хийх	Агаар-2 46° 16'28.37" 100°19'28.96"	8 сард	1				
Хөрсөн бүрхэвч							
Хөрсний ерөнхий шинжилгээ	Хөрс-1 46° 16' 32.49" 100° 19' 09.20"	8 сард	1	25.0	2 цэг х 2 дээж х 25.0 = 100.0	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, MNS 5859:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
Хөрсний бохирдлын шинжилгээ, хүнд металл	Хөрс-2 46° 16' 12.63" 100° 19' 30.13"		1	25.0	2 цэг х 1 дээж х 25.0 = 50.0		
Усны хяналт шинжилгээ							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Худаг -2 46°16'36.06" 100°18'49.32"	8 сард	1	46.0	НИЙТ 46.0 х 3 худаг х 1 жил = 138.0	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлан нөмрөг							
Ургамлан нөмрөгийн бичиглэл хийх	Ургамлын бичиглэл-1 46° 16' 30.07"	8 сард	2	-	-	Мэргэжлийн байгууллага,	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
	100° 19' 14.39" Ургамлын бичиглэл-2 46° 16' 11.07" 100° 19' 45.00"					шинжээчээр хийлгэх	ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх тухайн жилийн гүйцэтгэлийн зардал					408.0		

Тус төслийг хэрэгжүүлэх 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **24 630.0** мян.төгрөгийг төлөвлөж өглөө.

Зураг 26. ОХШХ хэрэгжүүлэх цэгийн байршлын зураг

